



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2024.07.30

№ 693

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БОР-ӨНДӨР  
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Бор-Өндөр сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол

232420720

Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Бор-Өндөр сумын Монгол ардын намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бор-Өндөр сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (9 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА


БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Ц.БИЛЭГСАЙХАН

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО

- 1.1. Орон сууц
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Боловсрол
- 1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт
- 1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт
- 1.6. Хүүхэд гэр бүлийн хөгжил

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хөдөө аж ахуй
- 2.2. Уул уурхай
- 2.3. Дэд бүтцийн сүлжээ
  - 2.3.1. Эрчим хүчний төсөл
  - 2.3.2. Агаарын тээвэр
  - 2.3.3. Авто зам



ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО



## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 1.1. Орон сууц

1.1.1. Төрийн албан хаагчид, залуучууд орлого багатай иргэдэд зориулсан түрээсийн орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх

1.1.2. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд төрийн хувийн хэвшлийн түшлэлийн төслийг хэрэгжүүлж, хөнгөлөлттэй орон сууцаар төрийн албан хаагчид болон иргэдийг хангах

1.1.3. Зорилтот бүлэг /төрийн албан хаагч, залуу гэр бүл/-д чиглэсэн орон сууцны төслийг хэрэгжүүлж, урьдчилгаа төлбөрийн батлан даалт, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэх

### 2. Эрүүл мэнд

1.2.1. Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтан албан хаагчдын санал санаачлагыг бүрэн дэмжиж, нийгмийн баталгааг ханган ажиллана.

1.2.2. Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлнэ.

1.2.3. Хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.

1.2.4. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.5. Стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн өрхийн эмнэлэг барьж ашиглалтад оруулна.

1.2.6. Эрүүл мэндийг байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай зохион байгуулна.



1.2.7. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.8. Хеликобактер, Сүрьеэ, БЗДХ-ийн эрт элрүүлгийг эрчимжүүлнэ.

### 1.3. Боловсрол

1.3.1. Уурхайчин 4 дүгээр багийн 200 хүүхэдтэй цэцэрлэгийг шаардлагатай тавилга, эд хогшил, тоног, төхөөрөмж, зөөлөн эдлэлээр хангана.

1.3.2. Боловсролын салбарын багш, ажилтан албан хаагчдын санал санаачлагыг бүрэн дэмжиж, нийгмийн баталгааг ханган ажиллана.

1.3.3. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

1.3.4. Сургууль, цэцэрлэгүүдэд STEM хөтөлбөр хэрэгжүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх, анги бүлгийг хэрэглэгдхүүнээр хангах, багш нарыг сургах, туршлага судлуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.

1.3.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын сургуулийн багш ажилчдын нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийн нэмэгдүүлэх, зорилгоор албан хаагчдын санал санаачилгыг дэмжин ажиллана.

1.3.6. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.3.7. Сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилт хийх кабинет байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.8. Багш, ажилчдыг чадавхжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.

1.3.9. Шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана.



1.3.10 Иргэд нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн өрсөлдөх чадвартай боловсролыг насан туршдаа тасралтгүй эзэмшдэг байх, гэр бүлийн иргэний ёс суртахуун төлөвшлийн амьдрах ухааны боловсрол олгох үйл ажиллагааг хүн бүрт хүртээмжтэй болгоно.

1.3.11 Хүүхдийг бүс, улс, олон улсын түвшинд өрсөлдөхүйч чанартай боловсрол эзэмших, хүүхэд бүрийн авъяас чадварыг хөгжүүлэхэд дэмжин ажиллана.

#### **1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт**

1.4.1. Иргэдийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр мэргэжлийн сургалтад хамруулан бүтээмжтэй, зохистой ажлын байрыг бий болгох замаар, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилтай, орлоготой болгоно.

1.4.2. Тусгай хэрэгцээ шаардлатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулж, орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуй нэгжийн тоог нэмэгдүүлнэ.

1.4.3. MNS ISO 45001:2018 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо”-ны стандартыг аж ахуйн нэгж байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлнэ.

1.4.4. Ахмад настнуудын дунд зохион байгуулагдаж буй спорт, соёл урлаг, нийгэм олон нийтийн арга хэмжээнд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

1.4.5. Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд шинэ ажлын байрыг 200-аар нэмэгдүүлнэ.

1.4.6. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.4.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.8. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдлаг өрхийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.



1.4.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.10. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас зарлагдаж буй арга хэмжээнүүдэд шаардлага хангасан иргэд, аж ахуй нэгжийг хамруулна.

### **1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт**

1.5.1. Соёл төвийн орчин нөхцлийг сайжруулах, шаардлагатай тоног хөрөөмжөөр хангах

1.5.2. Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

1.5.3. Соёлын үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, соёлын бодлого, шийдвэр гаргах үйл явцад уран бүтээлчид, аж ахуйн нэгжүүд цахимаар оролцох боломжийг нээлттэй болгоно.

1.5.4. Залуучуудын сургалт, спорт хөгжлийн төвийг барьж байгуулна

1.5.5. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, явган аялал, хөдөлгөөнт дасгал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.5.6. Өсвөр болон насанд хүрэгчдийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын сум, аймаг, бүс, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

### **1.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжил**

1.6.1. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.6.2. Хүүхэд гэр бүлд үзүүлэх хөгжлийн үйлчилгээг хамтарсан багаар гүйцэтгүүлэн, нийт хүүхэд гэр бүлийн 50 хувьд үйлчилгээ үзүүлнэ.



1.6.3. Гэр бүл, хүүхдэд сургалт хөгжлийн үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээг тогтмол үзүүлнэ.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 2.1. Хөдөө аж ахуй

2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлэх

2.1.2. Мал амьтны гаралтай арьс, шир, ноосыг боловсруулж, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл хөтөлбөрийг дэмжин ажиллана.

2.1.3. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монгол мал-II" арга хэмжээг аймагтаа хэрэгжүүлнэ.

2.1.4. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэн, хүлэмж, зoorь, хүнсний ногооны үрийн хангамжийг сайжруулж, дотоодын хэрэгцээний 15 хувийг хангана.

2.1.5. Бэлчээр хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, усан хангамжийг нэмэгдүүлнэ.

2.1.6. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын удмын санг хамгаалах, эрчимжсэн мал аж ахуйн төсөл арга хэмжээг дэмжин ажиллана.

2.1.7. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжин ажиллана.

2.1.8. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир, ноос боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.1.9. Малжуулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, шинэ залуу малчдыг дэмжин ажиллана.

2.1.10. Баялаг бүтээгчдээ бүх талаар дэмжих бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн баялаг бүтээгчдийг сурталчилж, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлнэ.

2.1.11. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, малыг гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулах, өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган ажиллана.





2.1.12. Туслах аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг бүх талаар нь дэмжин ажиллана.

## **2.2. Уул уурхай.**

2.2.1. Үйлдвэр технолигийн парк байгуулах ажлын хүрээнд хорголжингийн үйлдвэр байгуулна.

2.2.2. Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААНэгж, байгуулагуудтай хамтран ажиллах гэрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах асуудлыг тусган шийдвэрлэнэ

2.2.3.

## **2.3. Дэд бүтцийн сүлжээ**

### **2.3.1. Эрчим хүчний төсөл**

2.3.1.1. Шинэ суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах шугам татах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, суурьшлын бүсийг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.3.1.2. Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто замын дагуу гэрэлтүүлэг хийнэ.

2.3.1.3. Сумдын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ

### **2.3.3. Автозам**

2.3.3.1. Бор-Өндөр- Дархан- Баянмөнх- Чингис хот чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна.

2.3.3.2. Явган хүний зам, дугуйн замыг шат дараатайгаараа нэмэгдүүлнэ.

## **ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

3.1. Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, хот, суурин газрууд хог хаягдлын зориулалтын байгууламжтай болно. II зэргийн ландфил байгууламж бий болгоно.

3.2. Хог хаягдал ангилан ялгах цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах



3.3. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ

3.4 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.

3.5. Уул уурхайд үйлдвэрлэлийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ.

## **ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

4.1. Гал түймэр унтраах, аврах ангийн 3 дугаар зэрэглэлийн барилгыг барина.

4.2. Зайлшгүй шаардлагатай асуудлаар хяналт шалгалт хийх “НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ”-ыг тогтмол зохион байгуулж иргэдийн мэдэх эрхийг хангана.

4.3. Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

4.4. Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

4.5. Дэвшилтэд технологи бүхий хяналтын камерыг нэмэгдүүлэн, засвар үйлчилгээг тогтмолжуулна.

4.6. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

4.7. Тендер сонгон шалгаруулалт, газар олголт, орон нутгийн эд хөрөнгийн дуудлага худалдааг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна.

4.8. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах “Асуудлаас шийдэлд” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.9. “Зөгийн үүр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймаг орон нутагт шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэх, хөтөлбөрт хамруулна.



4.10. Орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллагад ажиллагсдад орон нутгийн нэмэгдлийг нэмэгдүүлэн олгоно.

### ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Уурхайчин 4 дүгээр багийн Геологийн байрыг инженерийн шугам сүлжээнд холбоно.

5.2. Хуучирч муудсан, эзэмшил нь тодорхойгүй, иргэд олон нийтийн аюулгүй амгалан байдалд сөргөөр нөлөөлөхүйц барилга байгууламжийг тогтоон нэг мөр цэгцлэх, газрыг чөлөөлүүлэх, буулгах, шинээр бүтээн босгож эдийн засаг, нийгмийн эргэлтэд оруулна

5.3. Сумын төвийн ариутгал татуургын шугам сүлжээг шинэчлэх, Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын зураг төслийг хийлгүүлэх

5.4. Сумын цэвэр усны худгийг нэмэгдүүлэх, ухаалаг системд үе шаттайгаар шилжүүлнэ.

5.6. Сумын хөгжлийн бодлоготой уялдуулан татварын тогтолцоог хөгжүүлж, суманд томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.

5.7 Төрийн байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хамгаалалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээ, хариуцлага тооцож ажиллана.

2317144297  
СНУА0046 9074082

5.8 Татварын орлогын төлөвлөлтийг сайжруулж бодитой болгох, батлагдсан төсвийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлнэ.

5.9. Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулж, хоршоо хөгжүүлэх сангийн журмын дагуу зээлийг олгоно.

5.10 Санхүүгийн сахилга батыг сайжруулж, төрийн аудитаар илэрдэг зөрчлийг бууруулна.

5.11. Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд шилэн дансны хэрэгжилтийг хангаж ажиллана.

